



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2022/708/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга, аудитын менежер: З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:munkhbayarz@audit.gov.mn">munkhbayarz@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a>
Улаанбаатар хот 2022 он	Ахлах аудитор: Г.Долгорсүрэн Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:dolgorsureng@audit.gov.mn">dolgorsureng@audit.gov.mn</a> Аудитор: Ш.Мөнхжаргал Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:munkhjargalsh@audit.gov.mn">munkhjargalsh@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

## Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий зөвлөл
НА	Нотлох ажил
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1.Төрийн аудитын газрын санал, дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.24 № 139  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН  
ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ж.ӨНӨРБАЯА  
ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

002020163

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,396,632.00</b>	<b>22,855,609.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	24,396,632.00	22,855,609.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	24,396,632.00	22,855,609.00
35410	Бичиг хэргийн материал	7,147,256.00	5,599,933.00
35420	Аж ахуйн материал	45,500.00	0
35440	Түлш, шатах тослох материал	3,220,000.00	754,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,983,876.00	16,501,676.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>755,553,591.64</b>	<b>802,629,588.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	755,553,591.64	802,629,588.73
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	752,866,612.46	800,668,859.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	535,533,622.89	604,235,622.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	0	-107,106,724.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,390,737.77	106,488,237.77
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,227,930.36	-12,142,322.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,633,235.10	197,810,115.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,964,410.70	-83,295,413.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,810,409.34	135,547,224.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,915,156.63	-52,959,022.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,056,355.05	13,503,555.05
39215	Хуримтлагдсан элэгдэл	-506,730.00	-1,664,725.32
39217	Ном	56,480.00	252,312.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,686,979.18	1,960,729.22
39301	Программ хангамж	2,905,000.00	2,905,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-218,020.82	-944,270.78
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>779,950,223.64</b>	<b>825,485,197.73</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>779,950,223.64</b>	<b>825,485,197.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	779,950,223.64	825,485,197.73
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	779,950,223.64	825,485,197.73
51210	Өмнөх үеийн үр дүн	201,720,999.29	779,950,223.64
51220	Тайлант үеийн үр дүн	578,229,224.35	45,534,974.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>779,950,223.64</b>	<b>825,485,197.73</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,856,277,381.94</b>	<b>1,547,805,867.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>595,345,721.94</b>	<b>195,090,767.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	595,345,721.94	195,090,767.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	595,345,721.94	195,090,767.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	594,262,741.94	192,726,747.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1082980	2364020
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,260,931,660.00</b>	<b>1,352,715,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,248,647,700.00	1,352,715,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,248,647,700.00	1,352,715,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,283,960.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,240,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,043,960.00	0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,278,048,157.59</b>	<b>1,502,270,892.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,278,048,157.59</b>	<b>1,502,270,892.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,236,055,452.59	1,481,838,036.30
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	927,486,111.00	1,033,169,443.00
210101	Үндсэн цалин	728,880,195.00	832,068,084.00
210102	Нэмэгдэл	106,577,743.00	96,520,345.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,176,500.00	57,881,720.00
210104	Урамшуулал	43,851,673.00	46,699,294.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	125,653,624.00	132,965,680.39
210201	Тэтгэврийн даатгал	85,490,508.00	95,350,993.32
210202	Тэтгэмжийн даатгал	10,040,780.00	8,927,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,155.00	7,339,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,032,667.00	2,207,187.07
210205	Эрүүл мэндийн даатгал	20,081,514.00	19,139,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,107,900.00	29,366,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,499,727.00	8,846,801.00
210302	Түлш, халаалт	18,662,944.00	17,866,055.00
210303	Цэвэр, бохир ус	1,472,529.00	2,153,144.00
210304	Байрны түрээс	1,472,700.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	76,695,300.00	72,440,732.00
210401	Бичиг хэрэг	27,985,682.00	25,701,803.00
210402	Тээвэр, шатахуун	5,030,000.00	4,110,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,842,500.00	21,359,627.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,895,200.00	1,826,190.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,941,918.00	19,443,112.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	382,600.00	999,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	382,600.00	999,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,768,870.00	29,259,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	452,400.00	7,398,300.00
210604	Урсгал засвар	8,316,470.00	21,861,350.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,199,550.00	11,376,601.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,437,830.00	8,382,101.00
210803	Даатгалын үйлчилгээ	478,620.00	2,556,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,800.00	69,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	346,500.00
210807	Газрын төлбөр	191,300.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	52,761,497.59	172,260,229.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	949,900.00	980,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,811,597.59	171,280,229.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	41,992,705.00	20,432,856.61
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,000,000.00	14,037,137.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	12,038,315.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	1,998,822.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	36,992,705.00	6,395,719.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,948,745.00	6,395,719.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,043,960.00	0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>578,229,224.35</b>	<b>45,534,974.09</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>578,229,224.35</b>	<b>45,534,974.09</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл			201,720,999.29	201,720,999.29
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	201,720,999.29	201,720,999.29
C07	Тайлант үеийн үр дүн			578,229,224.35	578,229,224.35
C08	2020 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	0.00	0.00	779,950,223.64	779,950,223.64
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	779,950,223.64	779,950,223.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	779,950,223.64	779,950,223.64
D08	Тайлант үеийн үр дүн			45,534,974.09	45,534,974.09
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	825,485,197.73	825,485,197.73

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,260,931,660.00</b>	<b>1,352,715,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,260,931,660.00</b>	<b>1,352,715,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,248,647,700.00	1,352,715,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,248,647,700.00	1,352,715,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,283,960.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,240,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,043,960.00	0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,226,299,660.00</b>	<b>1,327,085,620.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,226,299,660.00</b>	<b>1,327,085,620.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,184,306,955.00</b>	<b>1,306,652,763.39</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	927,486,111.00	1,033,169,443.00
210101	Үндсэн цалин	728,880,195.00	832,068,084.00
210102	Нэмэгдэл	106,577,743.00	96,520,345.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,176,500.00	57,881,720.00
210104	Урамшуулал	43,851,673.00	46,699,294.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	125,653,624.00	132,965,680.39
210201	Тэтгэврийн даатгал	85,490,508.00	95,350,993.32
210202	Тэтгэмжийн даатгал	10,040,780.00	8,927,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,155.00	7,339,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,032,667.00	2,207,187.07
210205	Эрүүл мэндийн даатгал	20,081,514.00	19,139,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,107,900.00	29,366,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,499,727.00	8,846,801.00
210302	Түлш, халаалт	18,662,944.00	17,866,055.00
210303	Цэвэр, бохир ус	1,472,529.00	2,153,144.00
210304	Байрны түрээс	1,472,700.00	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	70,222,510.00	64,821,989.00
210401	Бичиг хэрэг	30,000,000.00	24,072,560.00
210402	Тээвэр, шатахуун	7,200,000.00	1,644,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,860,000.00	21,359,627.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,906,000.00	1,826,190.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,256,510.00	15,919,612.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	1,000,000.00	999,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	999,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,841,360.00	32,973,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,206,490.00	11,112,000.00
210604	Урсгал засвар	11,634,870.00	21,861,350.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,045,550.00	11,376,601.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,283,830.00	8,382,101.00



Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	478,620.00	2,556,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,800.00	69,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	346,500.00
210807	Газрын төлбөр	191,300.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>949,900.00</b>	<b>980,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	949,900.00	980,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,992,705.00</b>	<b>20,432,856.61</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,000,000.00</b>	<b>14,037,137.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	12,038,315.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	1,998,822.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>36,992,705.00</b>	<b>6,395,719.61</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,948,745.00	6,395,719.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,043,960.00	0
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>34,632,000.00</b>	<b>25,629,480.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>34,632,000.00</b>	<b>25,629,480.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>34,632,000.00</b>	<b>25,629,480.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>34,632,000.00</b>	<b>25,629,480.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,632,000.00	25,629,480.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-34,632,000.00</b>	<b>-25,629,480.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,352,715,100.00</b>	<b>1,346,319,380.39</b>	<b>6,395,719.61</b>	<b>99.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,352,715,100.00</b>	<b>1,346,319,380.39</b>	<b>6,395,719.61</b>	<b>99.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,338,676,700.00</b>	<b>1,332,282,243.39</b>	<b>6,394,456.61</b>	<b>99.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,034,963,400.00</b>	<b>1,033,169,443.00</b>	<b>1,793,957.00</b>	<b>99.8</b>
210101	Үндсэн цалин	846,714,800.00	832,068,084.00	14,646,716.00	98.3
210102	Нэмэгдэл	126,224,000.00	96,520,345.00	29,703,655.00	76.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,451,600.00	57,881,720.00	(17,430,120.00)	43.1
210104	Урамшуулал	21,573,000.00	46,699,294.00	(25,126,294.00)	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НДШ</b>	<b>134,963,300.00</b>	<b>132,965,680.39</b>	<b>1,997,619.61</b>	<b>98.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	97,770,200.00	95,350,993.32	2,419,206.68	97.5
210202	Тэтгэмжийн даатгал	8,927,900.00	8,927,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,339,900.00	7,339,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,785,600.00	2,207,187.07	(421,587.07)	123.6

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	19,139,700.00	19,139,700.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,368,000.00</b>	<b>29,366,000.00</b>	<b>2,000.00</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,328,000.00	8,846,801.00	(518,801.00)	106.2
210302	Түлш, халаалт	17,610,000.00	17,866,055.00	(256,055.00)	101.5
210303	Цэвэр, бохир ус	3,084,000.00	2,153,144.00	930,856.00	69.8
210304	Байрны түрээс	346,000.00	500,000.00	(154,000.00)	144.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>64,910,000.00</b>	<b>64,821,989.00</b>	<b>88,011.00</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	24,080,000.00	24,072,560.00	7,440.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,644,000.00	1,644,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,360,000.00	21,359,627.00	373.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,906,000.00	1,826,190.00	79,810.00	95.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,920,000.00	15,919,612.00	388.00	100.0
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>999,700.00</b>	<b>300.00</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	999,700.00	300.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>58,720,000.00</b>	<b>58,602,830.00</b>	<b>117,170.00</b>	<b>99.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,500,000.00	30,497,280.00	2,720.00	100.0
210602	Тавилга	6,300,000.00	6,244,200.00	55,800.00	99.1
210604	Урсгал засвар	21,920,000.00	21,861,350.00	58,650.00	99.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,752,000.00</b>	<b>11,376,601.00</b>	<b>2,375,399.00</b>	<b>82.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,058,200.00	8,382,101.00	1,676,099.00	83.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	0	400,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,572,000.00	2,556,200.00	15,800.00	99.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	69,800.00	70,200.00	49.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00	22,000.00	50.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	346,500.00	346,500.00	-	100.0
210807	Газрын төлбөр	191,300.00	0	191,300.00	0.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1000000</b>	<b>980000</b>	<b>20,000.00</b>	<b>98.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	980,000.00	20,000.00	98.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,038,400.00</b>	<b>14,037,137.00</b>	<b>1,263.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,038,400.00</b>	<b>14,037,137.00</b>	<b>1,263.00</b>	<b>100.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,038,400.00	12,038,315.00	85.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2000000.00	1998822.00	1,178.0	99.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,352,715,100.00</b>	<b>1,346,319,380.39</b>	<b>6,395,719.61</b>	<b>99.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,352,715,100.00</b>	<b>1,346,319,380.39</b>	<b>6,395,719.61</b>	<b>99.5</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,352,715,100.00	1,346,319,380.39	6,395,719.61	99.5

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын аудитын хоёрдугаар хэлтсийн аудитор Ш.Мөнхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Шүүхийн захиргаа нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах  
Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх  
Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах;  
Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх  
Шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, шүүхийн цахим хуудсыг тогтмол шинэчлэх  
Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод хяналт шалгалтын хэлтсээс хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,278,048.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 25,560.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 20,448.7 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.3 хувиар буюу 45,534.9 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Бараа материал	24,396.6	22,855.6	(1,541.0)
Үндсэн хөрөнгө	755,553.7	802,629.6	47,075.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>779,950.2</b>	<b>825,485.1</b>	<b>45,534.9</b>
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	<b>779,950.2</b>	<b>825,485.1</b>	<b>45,534.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 22,855.6 мянган төгрөг болж өмнөх оноос 1,541.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд бичиг хэрэг 1,547.3.3 мянган төгрөгөөр, шатахуун тослох материал 2,466.0 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 45.5 мянган төгрөгөөр буурч, бусад хангамжийн материал 2,517.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 802,629.6 мянган төгрөг болж 47,075.9 мянган төгрөгөөр өссөн нь ШЕЗ-өөс 68,533.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 94,097.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 26,238.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,492.6 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авч орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 25,629.4 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 192,726.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 825,485.1 мянган төгрөг болж 45,534.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 308,471.5 мянган төгрөгөөр буюу 16,7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 224,222.7 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж бараа материал, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл зэрэг зардлууд байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2021 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,550,917.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 204,598.5 мянган төгрөгөөр бууруулж 1,352,715.0 мянган төгрөгөөр баталсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, тавилга эд хогшил худалдан авах, урсгал зардал, цалин хөлс нэмэгдэл урамшуулал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, хичээл сургалт, үйлдвэрлэлийн зардал, бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлсийн зардал зэргийг бууруулж баталсантай холбоотой.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 33 арга хэмжээг 1,352,715,0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,352,715.0 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны зардалд 1,346,319.4 мянган төгрөгийг зарцуулан, 6,395.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,346,319.4 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,793.9 мянган төгрөг, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын зардлыг 1,997.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,000.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 88.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 117.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 2,375.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 20.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

**ТАЙЛАНТ ОНД НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.**

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад ШЕЗ-өөс 19 нэр төрлийн 192,726.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 12 нэр төрлийн 2,364.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан ба уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Бусад асуудлын хэсэг:**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2021 онд нийт шилэн дансны цахим хуудсанд орлогын 1,358,406.9 мянган төгрөгийн 15 ажил гүйлгээ, зарлагын 110,963.0 мянган төгрөгийн 9 ажил гүйлгээ байршуулахаас орлогын 1,352,315.1 мянган төгрөгийн 13 ажил гүйлгээг хугацаандаа байршуулж, 6,091.3 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээ, зарлагын

110,963.0 мянган төгрөгийн 9 ажил гүйлгээний мэдээллийг бүрэн байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” заалтуудыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10.1. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12,556.1 мянган төгрөгийн зөрчлийн арилгах 2 зөвлөмж, 1 төлбөрийн актыг 100.0 хувь ханган биелүүлсэн.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	11,742.9	2	11,742.9	-	-	-
Төлбөрийн акт	1	813.2	1	813.2			
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>12,556.1</b>	<b>1</b>	<b>12,556.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 599,940.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 590,513.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,427.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:



1. Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны тайлант үеийн үр дүнг 578,229.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
2. Нэмэлтээр санхүүжилт аваагүй боловч 12,283.9 мянган төгрөгөөр тайлагнасан.

#### **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **4.2.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:**

*1.1.Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хуримтлагдсан элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй 44 ширхэг 3,506.8 мянган төгрөгийн хөрөнгөд дахин үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалтыг зөрчсөн.

*1.1.Өгсөн зөвлөмж:* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлж, үлдэгдэл өртөггүй болсон цаашид ашиглаж байгаа хөрөнгийг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх

##### **4.2.2. Зардлын данстай холбоотой асуудал**

*2.1 Илрүүлэлт:* Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 1,389.8 мянган төгрөгийн гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 5 дугаар зүйлийн 5.1.4 ."үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.1.4. "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:* Анхан шатны баримтын бүрдлийн хангах, хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг бүртгэж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

##### **4.2.3. Зардлын данстай холбоотой асуудал**

*3.1 Илрүүлэлт:* Тайлант онд гарсан зардлын 8,037.2 мянган төгрөгийн баримт төлбөрийн дахин давтагдашгүй дугаар бүхий баримтаар нотлогдохгүй, худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч

төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудыг зөрчсөн.

3.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/ Д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны тайлант үеийн үр дүнг дутуу тайлагнасан.	1	578,229.2	1	578,229.2						
2	Нэмэлтээр санхүүжилт аваагүй боловч тайлагнасан.	1	12,283.9	1	12,283.9						
3	Үлдэх өртөггүй болсон хөрөнгийг шийдвэр гаргуулан дахин үнэлээгүй.	1	-							1	-
4	Анхан шатны баримтыг бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хийж данс бүртгэлд тусгасан.	1	1,389.8							1	1,389.8
5	Зардлын баримт төлбөрийн дахин давтагдашгүй дугаар бүхий баримтаар нотлогдохгүй байна.	1	8,037.3							1	8,037.3
	Дүн		599,940.2	2	590,513.1					3	9,427.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал:											
1	Шилэн дансны мэдээлэл бүрэн байршуулаагүй.	1	-					1	-		
	<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>599,940.2</b>					<b>1</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>9,427.1</b>

